

БАТЛАВ: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА:  Д.СОНДОМ

**МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ Н.ТҮМЭН-ӨЛЗИЙН
НЭРЭМЖИТ “ МОНГОЛ БИЧИГ МИНУ –ХХІ ” ГОВИЙН БҮСИЙН
ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

2024 оны 04 сарын 20 өдөр

Үндэслэл: Монгол улсын ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- 3” – ыг хэрэгжүүлэх, Үндэсний бичгийн хэрэглээг олон нийтийн хүртээл болгож, хос бичигтэн болох, үндэсний өв соёлоо хамгаалж хөгжүүлэх, “Үндэсний бичиг үсгийн баяр” ын арга хэмжээнд зориулан зохион байгуулна.

Зорилго: Үндэсний бичгийн хэрэглээг өргөтгөж, сургалтын орчин, сургах боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх, иргэдийн идэвх, сонирхлыг дэмжин, үндэсний бичгээ сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.

Хугацаа: 2024 оны 05 дүгээр сарын 11нд

Хамрах хүрээ: Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн ЕБС –ийн мэргэжлийн багш нар, 6-12-р ангийн сурагчид, аймгийн иргэд, төрийн байгууллага, төрийн албан хаагчид

Зохион байгуулалт:

2024 оны 05 дугаар сарын 09-нд төрийн байгууллагыг шалгаруулна.

2024 оны 05 дүгээр сарын 11-нд Олимпиадын зохион байгуулалт, шагнал гардуулах арга хэмжээ Боржигин чуулгад зохион байгуулагдана.

Олимпиадын үеэр 1 дүгээр сургуулийн Монгол бичгийн танхимд аймгийн ЕБС,МБСБ -ын багш нарын уран бичлэгийн үзэсгэлэн, аймгийн “Боржигин өв музей” үзүүлнэ.

Олимпиадын ангилал:

1.Говьсүмбэр аймгийн төрийн байгууллага шалгаруулах чиглэл

- Байгууллагын нэр дотор, гадна хаягийг монгол бичгээр бичсэн байна.
- Монгол бичигт тайлагдсан албан хаагчдын тоо, сургалтад хамрагдсан ирц
- Байгууллагад хэрэгжүүлж буй хөтөлбөр, санаачлан хийсэн шинэлэг ажил
- “Хүмүн бичиг” сонин захиалан уншдаг иргэдийн тоо /хувиар/
- Олимпиадын иргэдийн ангилалд оролцсон байдал /5 хүртэлх иргэдийг заавал оролцуулна.

- Байгууллагын албан бичгийг хос хэлээр хөрвүүлсэн байх. /Байгууллагын архив бичиг хэргийн ажилтан биеэр ирж оролцоно. Өгсөн сэдвийг цахимд бичих -Unicode/

Төрийн байгууллагын удирдалгууд дээрх 6 шалгуурын хангасан тайлан мэдээллээ бэлтгэж, архив бичиг хэргийн ажилтаны хамт 2024 оны 5 сарын 09-ний 14.00 цагт 5 дугаар сургуулийн Монгол хэлний танхимд ирж олимпиадын комисст тайлангаа тавина.

2. Монгол бичгийн олимпиад:

- 6-12-р ангийн төрөлд: Анги тус бүрт бусад аймгуудаас 3 сурагч, 3 багш, Говьсүмбэр аймгийн сургууль тус бүрээс 5 хүртэл сурагч оролцож болно. / Анги дэвшүүлэн оролцуулахгүй/
- Монгол бичгийн мэргэжлийн багш нар
- Бага ангийн багш нар
- Говьсүмбэр аймгийн мэргэжлийн багш нарын цахим бичвэрийн олимпиад /бүх багш нар оролцоно/
- Говьсүмбэр аймгийн төрийн байгууллага
- Говьсүмбэр аймгийн иргэд:
 - Үндсэн монгол бичигтэн иргэд /1991,1992,1993 оны 1-р ангийн элсэгчид/
 - Сонирхогч иргэд
- Говьсүмбэр аймгийн Иргэдийн Монгол бичгийн хурдан шударгуу тод уншигч

Санхүүжилт: Аймгийн “Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр”-ийн төсвөөс санхүүжүүлнэ.

Олимпиадын шалгаруулалт: Төрөл тус бүрт 1-3 дугаар байрыг шалгаруулж, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.

Олимпиад зохион байгуулагч:

Говьсүмбэр аймгийн Засаг Даргын тамгын газар,
Аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газар,
Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл
Сүмбэр сумын 1 дүгээр сургууль